



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас
балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Аялал жуулчлалын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 166,138,000.00 (нэг зуун жаран зургаан сая нэг зуун гучин найман мянга) төгрөгийн балансын үнэ, 94,606,361.02 (ерэн дөрвөн сая зургаан зургаан мянга гурван зуун жаран нэгэн төгрөг хоёр мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг “Өвөрхангай-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. “Аялал жуулчлалын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Пүрэвжав, “Өвөрхангай-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Лхам-Оролмаа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:


2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;


2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.


ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

 Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

 Б.ГАВАА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн
122 дугаар тогтоолын хавсралт



"АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨГЖЛИЙН ТӨВ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ, "ӨВӨРХАНГАЙ-АЗЗА" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ

Д/д	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, арал, хөдөлгүүрийн дугаар	Ашиглалтад орсон огноо	Нийт гүйлт /км/	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Ландкрудер-200, суудлын, 75-53 УНД	2013.12.16	89 752	166 138 000,00	94 606 361,02	71 531 638,98
	НИЙТ ДҮН	-	-	166,138,000.00 (нэг зуун жаран зургаан сая нэг зуун гучин найман мянган)	94,606,361.02 (ерэн дөрвөн сая зургаан зуун мянган төгрөг гурван зуун жаран нэгэн төгрөг хоёр мөнгө)	71,531,638.98 (далан нэгэн сая таван зуун гучин нэгэн мянга зургаан зуун гучин найман төгрөг ерэн найман мөнгө)